



МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2023.01.10 № 01/103

танай _____-ны № _____-т

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ
ХОРООНД

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт
жендэрийн талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны
тайланг 2022 оны байдлаар гарган хавсралтаар
хүргүүлж байна.

Мөн тайланг цахим хэлбэрээр Жендэрийн
үндэсний хорооны ахлах мэргэжилтэн О.Буянаагийн
buyanaa@ncse.gov.mn албаны хаягаар болон “жендэр
статистик програм” хангамжид /medee.1212.mn/
тайлагнав.

Хавсралт ⁹⁴ хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА  Т.ЖАМБАЛЦЭРЭН



00000203

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
 үйлдвэрийн яамны Төрийн
 нарийн бичгийн даргын 2023
 оны 1 дүгээр сарын 10-ны
 өдрийн 01/12 дугаар албан
 бичгийн хавсралт

ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

№	Салбар зөвлөлийн гишүүний овог нэр	Хүйс	Байгууллага, албан тушаал/ Мэргэжил	Улсад ажилласан жил	Төрийн албанд ажилласан жил	“Жендэр ба бодлого төлөвлөлт” анхан шатны сургагч багшийн гэрчилгээ авсан эсэх	Төрийн албаны удирдах албан тушаалтны жендэрийн цахим сургалтад хамрагдсан эсэх	Утасны дугаар	Цахим хаяг	Жендэрийн салбар зөвлөлийн чиг үүргийн хүрээнд хариуцаж буй үйл ажиллагааны чиглэл /
1	Т.Жамбалцэрэн	Эрэгтэй	ХХААХҮЯамны Төрийн нарийн бичгийн дарга	13	11	Үгүй	Тийм	9111-9333	jambaltseren@mofa.gov.mn	Дарга
2	Т.Гантогтох	Эрэгтэй	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	18	18	Үгүй	Тийм	9904-7657	gantogtoh@mofa.gov.mn	Гишүүн
3	Ц.Болорчулуун	Эрэгтэй	Бодлого, төлөвлөлтийн газрын дарга	23	18	Үгүй	Тийм	9910-5090	bolorchuluun@mofa.gov.mn	Гишүүн
4	Б.Санчирдорж	Эрэгтэй	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга	20	20	Үгүй	Үгүй	9911-7566	sanchirdorj@mofa.gov.mn	Гишүүн
5	Б.Отгонцэцэг	Эмэгтэй	Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга	25	20	Үгүй	Тийм	9918-6900	otgontsetseg.mofa@gmail.com	Гишүүн
6	М.Чулуунцэцэг	Эмэгтэй	Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөц, сургалтын асуудал	23	17	Үгүй	Үгүй	9908-3734	chuluuntsetseg@mofa.gov.mn	Гишүүн

			хариуцсан ахлах мэргэжилтэн							
7	Д.Отгонжаргал	Эмэгтэй	Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ургамлын гаралтай хүнсний үйлдвэрлэл, хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	15	6	Үгүй	Үгүй	8902-9516	otgoo_d1017@yahoo.com	Гишүүн
8	Н.Цэгмэд	Эмэгтэй	Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн	22	22	Үгүй	Үгүй	9913-1616	mofa@mofa.gov.mn	Гишүүн
9	Д.Батчулуун	Эрэгтэй	Мал, эмнэлгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч			Үгүй	Үгүй	8877-9139	batchuluun@vet.gov.mn	Гишүүн
10	Я.Эрдэнэсайхан	Эрэгтэй	Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга	20	17	Үгүй	Тийм	9911-0815	erdenesaikhan@sme.gov.mn	Гишүүн
11	Т.Жанцанхорол	Эрэгтэй	Монголын хөдөө аж ахуйн дэвшил холбооны удирдах зөвлөлийн дарга	46	46	Үгүй	Үгүй	9918-7266	jangaa.d89@gmail.com	Гишүүн
12	Л.Отгонболор	Эмэгтэй	Төрийн захиргааны удирдлагын газрын жөндөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн	21	21	Тийм	Үгүй	9910-2367	Otgonbolor@mofa.gov.mn	Нарийн бичгийн дарга

**Төрийн захиргааны төв, түүний харъяа агентлагт ажиллаж буй албан хаагчдын
2022 оны хүйсийн тэнцвэрт байдлын жилийн мэдээ**

Тайлбар:Төрийн захиргааны төв байгууллага нь хавсралт 3-ын Маягт 1а, 1б, 1в, 1г, 1д, 1е-д заасан “яам”, “харъяа агентлаг” гэсэн мөрийг байгууллага тус бүрээр бөглөж, ЖҮХ-нд ирүүлнэ.

Маягт 1а

№	Төрийн захиргааны төв болон түүний харъяа агентлагийн нэр	Төрийн албан хаагчид /үндсэн/		
		Нийт	Үүнээс	
			эр	эм
1	Яам	114	47	67
2	Мал эмнэлгийн ерөнхий газар	38	20	18
3	Жижиг, дунд үйлдвэрийн газар	35	13	22

Маягт 1б

№	Төрийн захиргааны төв байгууллагын нэр	Томилогдох төрийн улс төрийн албан хаагч		Үүнээс					
		эр	эм	Сайд		Дэд сайд		Бусад	
				эр	эм	эр	эм	эр	эм
1	Яам	3		1		1		1	

Маягт 1в

№	Төрийн захиргааны төв байгууллагын нэр	Төрийн захиргааны албан хаагч		Үүнээс							
		эр	эм	Төрийн нарийн бичгийн дарга		Удирдах (газар хэлтсийн дарга)		Гүйцэтгэх		Туслах	
				эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
1	Яам	43	59	1		7	6	35	38	-	-

№	Төрийн захиргааны төв байгууллагын харъяа агентлагийн нэр	Төрийн захиргааны албан хаагч		Үүнээс							
		эр	эм	Агентлагийн дарга		Удирдах (хэлтэс, албаны дарга)		Гүйцэтгэх		Туслах	
				эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
1	Мал эмнэлгийн ерөнхий газар	18	14	1		4	1	13	13		
2	Жижиг, дунд үйлдвэрийн газар	12	16	1		3	2	8	14		

Маягт 1г

№	Үүнээс							
---	--------	--	--	--	--	--	--	--

	Төрийн захиргааны төв байгууллагын нэр	Төрийн тусгай албан хаагч		Төрийн нарийн бичгийн дарга		Удирдах (газар хэлтсийн дарга)		Гүйцэтгэх		Туслах	
		эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
1	Яам										

№	Төрийн захиргааны төв байгууллагын харьяа агентлагийн нэр	Төрийн тусгай албан хаагч		Үүнээс							
				Агентлагийн дарга		Удирдах (газар хэлтсийн дарга)		Гүйцэтгэх		Туслах	
		эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
1	Агентлаг										
2	Агентлаг										

Маягт 1д

№	Төрийн захиргааны төв байгууллагын харьяа агентлагийн нэр	Төрийн үйлчилгээний албан хаагч		Үүнээс							
				Агентлагийн дарга		Удирдах (газар хэлтсийн дарга)		Гүйцэтгэх		Туслах	
		эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
1	Яам	4	2								
2	Мал эмнэлгийн ерөнхий газар	2	4								
3	Жижиг, дунд үйлдвэрийн газар	1	6								


Маягт 1ө

№	Хороо, зөвлөл, комиссын нэр	Байгуулсан тушаал шийдвэр	Нийт бүрэлдэхүүний тоо	Дарга/ахлагч		Гишүүд	
				эр	эм	эр	эм
1	Яам						
1. ХХААХҮ-ийн сайдын ахалсан хороо, зөвлөл							
	ХХААХҮ-ийн сайдын бүрэлдэхүүн	2020.08.18 А-271	13	1		6	6
2. ХХААХҮ-ийн дэд сайдын ахалсан хороо, зөвлөл							
	ХХААХҮЯамны Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн	2021.02.08 А-25	22	1		14	7
3. ХХААХҮЯамны Төрийн нарийн бичгийн даргын ахалсан хороо, зөвлөл							
	Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн	2022.06.27 А/207	14 /2 хүн томилогдоогүй/	1		7	5
2	Агентлаг						
1. Мал эмнэлгийн ерөнхий газар							
	Малын эмийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн	2022.10.25 А/333	8	1		5	2
	Малын эмийн фармакопейн хорооны бүрэлдэхүүн	2022.10.25 А/333	9		1	5	3

	Жендэрийн дэд салбар зөвлөл байгуулах тухай	2022.12.12 A/247	8	1		3	4
	2. Жижиг, дунд үйлдвэрийн газар						
	Барьцаа хөрөнгийн ажлын хэсэг	2022.11.25 A/103	7	1		1	5
	Төсөл сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүн	2022.10.20 A/101	8	1		5	2
	Байгууллагын жендэрийн зөвлөл байгуулах тухай	2021.06.15 A-38	5	1			4

Тайлбар:

- Төрийн захиргааны төв байгууллага нь: 1/ "Салбарын сайдын ахалсан үндэсний болон салбарын хэмжээний хороо, зөвлөл, комисс", 2/ "Төрийн нарийн бичгийн даргын ахалсан хороо, зөвлөл, комисс", 3/ "Харъяа агентлагийн дарга нарын ахалсан хороо, зөвлөл, комисс" гэсэн мөрөн дэх мэдээллийг байгууллага тус бүрээр гаргаж, нэгтгэхгүйгээр тайлагнана.
- Төрийн захиргааны төв байгууллагын харъяа агентлаг нь: "Агентлагийн даргын ахалсан хороо, зөвлөл, комисс" гэсэн мөрөнд тухайн агентлагийн дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн мэдээллийг гаргаж, яаманд тайлагнана. Энэ мэдээнд орон нутаг дахь босоо удирдлагатай байгууллагуудын дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн судалгааг оруулахгүй.





МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 1707

Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн,
ажиллах журмыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор баталсан Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, хөгжлийн зорилтот хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар туссан зорилт, Жендэрийн үндэсний хорооноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг жил бүрийн яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд төсвийн хамт тусган батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Жендэрийн салбар зөвлөл /Т.Жамбалцэрэн/-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн "Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай" А-92 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

МЭНДСАЙХАН

00000602

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайдын 2022 оны 06... дугаар
сарын 17-ны өдрийн 1209 дугаар
туцаалын 1 дүгээр хавсралт

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Салбар зөвлөлийн дарга:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөц, сургалтын асуудал хариуцсан мэргэжилтэн
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ургамлын гаралтай хүнсний үйлдвэрлэл, хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн мэргэжилтэн
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга
- Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга
- Монголын хөдөө аж ахуйн дэвшил холбооны удирдах зөвлөлийн дарга

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргааны удирдлагын газрын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайдын 2022 оны 06 дугаар
сарын 27-ны өдрийн 17-дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Жендэрийн үндэсний хорооны Жендэрийн салбар зөвлөл /цаашид "салбар зөвлөл" гэх/-ийн зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино

1.2. Салбар зөвлөл нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Жендэрийн үндэсний хорооны дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий яамны хэмжээнд ажиллах Жендэрийн үндэсний хорооны зохион байгуулалтын бүтцийн нэгж юм.

ХОЁР. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайдын тушаалаар батлуулж мөрдөнө.

2.2. Салбар зөвлөл нь ажлаа Сайдын өмнө хариуцан тайлагнана.

2.3. Салбар зөвлөл нь төрийн харьяа байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангасан байх ба аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас багагүй байна.

2.4. Салбар зөвлөл нь салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга /жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн/, гишүүдээс бүрдэнэ.

2.5. Салбар зөвлөл нь харьяа агентлаг, байгууллагуудад дэд зөвлөлтэй байна. Салбар зөвлөл нь дэд зөвлөлийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана. Дэд зөвлөл нь бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрмийг энэхүү журамд нийцүүлэн боловсруулж, байгууллагын удирдлагын шийдвэрээр баталж мөрдөнө. Дэд салбар зөвлөл нь салбар зөвлөлийн өмнө ажлаа хариуцан тайлагнана.

2.6. Салбар зөвлөл нь дэд салбар зөвлөлийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.

2.7. Яамны жендэрийн салбар зөвлөл нь 11-15 хүртэл, дэд зөвлөл нь 5-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.8. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Салбар зөвлөлийн хуралдааныг жилд 4-өөс доошгүй /улирал тутам/ удаа хийнэ. Хуралдааныг салбар зөвлөлийн дарга удирдан явуулна.

2.9. Шаардлагатай тохиолдолд салбар зөвлөлийн ээлжит бус хурлыг салбар зөвлөлийн даргын санаачилгаар, эсхүл зөвлөлийн гишүүдийн олонхийн санаачилгаар зарлан хуралдуулж болно. Гишүүдийн 50-иас дээш хувь нь ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.10. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.11. Салбар зөвлөл нь хуралдааны дэгийг энэ журамд нийцүүлэн өөрөө тогтооно.

2.12. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тушаал, хурлын тэмдэглэл гарна.

2.13. Салбар зөвлөл нь хэлэлцсэн асуудлаарх холбогдох шийдвэрийг харьяа байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

2.14.Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд хүлээсэн үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа биелүүлээгүй тохиолдолд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВ. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ

3.1.Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд:

3.1.1.Салбарын бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө зэрэг баримт бичгийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаарх дүн шинжилгээг тогтмол хийж, үнэлгээний тайлан, зөвлөмжийн хамт Засгийн газарт өргөн мэдүүлэх; Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг салбарын хууль тогтоомж, бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, төсөл, шийдвэрт тусгах;

3.1.2.Салбарын хууль, бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, шийдвэрийг дэмжих хүрээнд салбарын жендэрийн бодлого болон түр тусгай арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, шийдвэрийн төслийг Засгийн газар болон салбарын сайдад өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

3.1.3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж, бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн төслийг боловсруулж, яам, салбар зөвлөлийн гишүүн байгууллагуудын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулан, тухайн оны эхний улиралд багтаан баталж, Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх;

3.1.4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж, бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, хууль тогтоомжийн дагуу тайлагнах;

3.1.5.Төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах, хэрэгжилтийг тайлагнах;

3.1.6.Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай салбар, орон нутгийн чадавхыг бэхжүүлэх;

3.1.7.Салбар, орон нутгийн байгууллага болон түншлэгч байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжиж, салбар дундын зохицуулалтыг хангах;

3.1.8.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлаар байгууллага, иргэнийг шагнал урамшуулалд тодорхойлох.

3.1.9.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан холбогдох тайлан мэдээг бэлтгэж, тогтоосон хугацаанд Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх;

3.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хүрээнд:

3.2.1.Салбар зөвлөлийн гишүүдийн жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, холбогдох бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар тусгах, хэрэгжилтийг үнэлэх хүрээнд жендэрийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлтийг боловсруулж, хяналт үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлэх;

3.2.2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтэд оролцоонд суурилсан хяналт шинжилгээг жил бүр, үнэлгээг хууль, бодлогод заасан хугацаанд тус тус хийж гүйцэтгэх, дүнг Жендэрийн үндэсний хороонд тайлагнах;

3.2.3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтэд оролцоонд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагыг татан оролцуулах.

3.3.Жендэр статистик мэдээллийг бүрдүүлэх, ашиглах, олон нийтэд хүргэх хүрээнд:

3.3.1.Салбарын хэмжээнд эрхэлж буй асуудлын хүрээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх;

3.3.2.Салбарын хүйсээр ангилсан статистикийн мэдээлэлд үндэслэн жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх, үнэлгээнд үндэслэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах;

3.3.3.Салбарын хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг эмхэтгэн, хэрэглэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах;

3.3.4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8, 19.1.9-д заасан тайланг бэлтгэх ажлыг хариуцан зохион байгуулах.

3.4.Жендэрийн сургалт, судалгаа, гэгээрлийн ажлын хүрээнд:

3.4.1.Салбарын ажилтан, албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, ЖЭТБХтХууль тогтоомжийг таниулан сурталчлах;

3.4.2.Жендэрийн үндэсний хорооны цахим хуудаст байрших "Удирдах албан тушаалтнуудад зориулсан жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх цахим сургалт"-д хамрагдаж, гэрчилгээ авах;

3.4.3.Салбарын мэдээлэл, гэгээрэл, сурталчилгааны ажлыг жендэрийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх, хүнийг ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах зорилгод нийцүүлэн зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

3.4.4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж, төрийн бодлого, тэдгээрийг хэрэгжүүлж буй сайн туршлагыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад таниулан сурталчлах ажлыг хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

3.4.5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэний үйл ажиллагааг дэмжиж, тэдгээртэй хамтран ажиллах.

3.5.Хөдөлмөрийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах хүрээнд:

3.5.1.Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх ЖЭТБХтХуулийн 11 дүгээр зүйл (Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын 7 дугаар зүйлд заасан дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх)-д заасан ажил олгогчийн үүргийн хэрэгжилтийг салбарын төр, төрийн бус байгууллагуудад хангуулах ажлыг зохион байгуулж, холбогдох дэмжлэгийг үзүүлж ажиллах;

3.5.2.Салбарын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг салбарын хүйсийн судалгаанд үндэслэн боловсруулан хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд түр тусгай арга хэмжээг авах саналыг боловсруулж, шийдвэрлүүлэх;

3.5.3.ЖЭТБХтХ-ийн 10 дугаар зүйлд заасан төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангаж, төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал, эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай зөвлөмж, дүгнэлтийг гаргаж, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

3.5.4.Салбарын хэмжээнд байгуулагдан ажиллаж буй хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэрт байдлыг хангуулах, хэрэгжилтийг тайлагнах;

3.5.5.Хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан ажилтны мэргэжил, мэргэшлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөж чадахуйц 11 Төрийн захиргааны төв байгууллагад зориулав түвшинд байлгах зорилгоор тэднийг давтан сургалтад хамруулах бодлогыг салбарын хэмжээнд авч хэрэгжүүлэх;

3.5.6.Ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх, ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан

сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг хөдөлмөрийн дотоод журамд тусгуулах ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах;

3.5.7. Байгууллагын түвшинд жендэрийн мэдрэмжтэй байгууллагын соёл, ажил ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах, гэр бүлийн үүргээ хослуулах, эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрийн эрүүл, аюулгүй, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хийхэд арга зүйн зөвлөгөө өгөх;

3.6. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх хүрээнд:

3.6.1. Салбарын бодлого, хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, төсөвлөх арга зүйг нэвтрүүлэх;

3.6.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон төрөөс үзүүлж, байгаа бүх төрлийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.6.3. Охид, эмэгтэйчүүд, эрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ажилтан, албан хаагчид/-ийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, хөнгөлөлттэй зээл, нийгмийн хамгааллын бодлого, үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх;

ДӨРӨВ. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

4.1. Салбар зөвлөлийн дарга нь Жендэрийн үндэсний хорооны гишүүн байх бөгөөд Сайдын өмнө ажлаа хариуцаж дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн зорилго, стратегийг тодорхойлох;

4.1.2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэд салбар зөвлөлийн үйл ажиллагаатай уялдуулан нийцүүлэх, нэгтгэн зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4.1.3. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоон хөтөлбөрийг баталж, хуралдааныг даргалан холбогдох асуудлыг хэлэлцүүлэх;

4.1.4. Салбар зөвлөлийн гишүүдийн хариуцах ажил үүргийг тухайн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийн хамт тусгуулж, биелэлтийг тооцох;

4.1.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар Сайдад тайлагнах; өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах;

4.1.6. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан холбогдох тайлан, мэдээллийн бодит байдалд хяналт тавих;

4.1.7. Салбар зөвлөлийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцах;

4.1.8. Салбар зөвлөлийн гишүүний ажил үүргийн биелэлтийг дүгнэж, урамшуулах, шаардлага тавих, хариуцлага хүлээлгэх;

4.1.9. Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын ачаалал, үр дүн, ур чадвартай нь уялдуулан холбогдох хууль, журамд нийцүүлэн дэмжих, урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах;

4.1.10. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр зарцуулж буй төсвийн зарцуулалтад хяналт тавих.

4.2. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.2.1. Салбар зөвлөлийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлаар Салбар зөвлөлийн даргад дэмжлэг үзүүлж ажиллах;

4.2.2. Салбар зөвлөлийн дарга, гишүүдийг жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр холбогдох мэдээ мэдээллээр хангах;

4.2.3. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, гишүүдэд урьдчилан танилцуулж, санал авах, нэгтгэн боловсруулах;

4.2.4. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг салбар зөвлөлийн даргаар батлуулах;

4.2.5.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам тооцож, салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулан хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;

4.2.6.Салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

4.2.7.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19.1.8, 19.1.9-д талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн тайланг Үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, зааврын дагуу холбогдох дэд салбар зөвлөлүүдээс авч нэгтгэн боловсруулж, холбогдох албан тушаалтнаар албажуулан тогтоосон хугацаанд (дэлгэрэнгүй тайлангийн хамт) Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх;

4.2.8.Түүнчлэн Яам болон түүний харьяа агентлаг байгууллагын дэргэдэх үндэсний хэмжээний хороо зөвлөл, комиссын төлөөллийн хүйсийн мэдээллийг бүрдүүлж, Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх;

4.2.9.Салбар зөвлөлийн хуралдааны тэмдэглэл болон холбогдох тайлан, мэдээллээр архивын нэгж бүрдүүлэн хуульд заасан хугацаанд байгууллагын архивт хүлээлгэн өгөх.

4.3.Салбар зөвлөлийн гишүүд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.1.Салбар зөвлөлийн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд биечлэн оролцох;

4.3.2.Салбар зөвлөлийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан ажлыг чиг үүргийн дагуу хариуцан зохион байгуулах, тайлагнах;

4.3.3.Салбар зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар санал гаргах, хуралдаанаар хэлэлцүүлэх;

4.3.4.Салбар зөвлөлийн даргын эзгүйд түүний даалгаснаар хурал удирдах, эрх бүхий байгууллагын шийдвэрээр салбар зөвлөлийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэх;

4.3.5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр тасралтгүй суралцах, мэргэших;

4.3.6.Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж байгаа аливаа арга хэмжээнд биечлэн оролцох, холбогдох удирдлага, албан тушаалтнуудыг оролцуулах.

ТАВ. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮЖИЛТ

5.1.Салбарын зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн болон зохион байгуулалтын зардлыг тухайн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

5.2.Гишүүд өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд салбар зөвлөлийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн яам

Нэгжийн нэр:

Төрийн захиргааны удирдлагын газар

Албан тушаалын нэр:

Тогтоол шийдвэрийн биелэлт,
дотоод асуудал хариуцсан
мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а,
Засгийн газрын IX байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй


II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын шийдвэр, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт гаргах, жендэрийн тэгш байдлыг хангах салбар хорооны ажлыг зохион байгуулах, газрын дотоод үйл ажиллагаатай холбоотой асуудал хариуцан гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Монгол Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг хүлээн авч, нэгтгэн ХШУДАГ-т хүргүүлэх;
- 2.Засгийн газрын үйл ажиллагааны хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг хүлээн авч, нэгтгэн ХШУДАГ-т хүргүүлэх;
- 3.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг хүлээн авч, нэгтгэн ХШУДАГ-т хүргүүлэх;
- 4.Жендерийн тэгш байдлыг хангах салбар хорооны ажлыг зохион байгуулах;
- 5.Төрийн захиргааны удирдлагын газрын дотоод ажил хариуцах;
- 6.Хууль, тогтоомжоор олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын Их хурлын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг улирал бүр хүлээн авч, нэгтгэн ХШУДАГ-т хүргүүлэх	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангасан байна	Г
	2.Тогтоол, шийдвэрийг холбогдох журмын дагуу архивын нэгж болгон цэгцэлж, хүлээлгэн өгөх	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангасан байна	Г
	3.Яаманд ирүүлсэн тогтоол, шийдвэрийг цахим хэлбэрт шилжүүлж, дотоод сүлжээнд байршуулах, холбогдох албан хаагчдад танилцуулах.	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангасан байна	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Засгийн газрын үйл ажиллагааны хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг хүлээн авч, нэгтгэн улирал бүр ХШУДАГ-т хүргүүлэх.	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангасан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хүнс, хөдөө аж ахуйн	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангасан байна.	

	хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний заалтыг хяналтад авч, хэрэгжилтийн тайланг хүлээн авч, нэгтгэн улирал бүр ХШҮДАГ-т хүргүүлэх.	хангасан байна.	
4 дүгээр зорилтын хүрээнд	Жендерийн тэгш байдлыг хангах салбар хорооны ажлыг зохион байгуулах.	ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-94 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангасан байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	Төрийн захиргааны удирдлагын газрын дотоод ажил хариуцах	Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах	Г
6 дугаар зорилтын хүрээнд	1.Дотоод журмыг чанд мөрдөж ажиллах, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь тайлагнах.	Биелэлтийг хугацаанд нь тайлагнасан байна.	Г
	2.Иргэд, албан байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, албан бичгийг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэх,	Албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г
	3.Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн боловсруулалтыг стандартын дагуу үйлдэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу тайлангийн жилд зохион бүрдүүлсэн ажлын холбогдох, баримтыг байгууллагын архивт хугацаанд нь бүртгэлээр хүлээлгэн өгөх.	Архивын баримтыг архивын нэгжид хугацаанд хүлээлгэн өгсөн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Төрийн захиргааны удирдлага /041303/, Эрх зүйч /042101/, Хөдөө аж ахуй /081/



Мэргэшил		Төрийн албанд мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх
Туршлага		Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай байх; - асуудлын шийдэлд шинэлэг байдлыг нэвтрүүлдэг байх; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байж, бусдыг дэмжих, үлгэрлэх; - шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - багийн ажлын гүйцэтгэл хангалтгүй тохиолдолд хариуцлага хүлээх чадвартай байх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт техник, технологи ашиглах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;

IV-АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

1.Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Үндэсний аудитын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, агентлагийн газар, хэлтэс, нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан


2.Хандивлагч орон, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн



	ажилтан; 3.Төрийн бус байгууллага, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, иргэн, хуулийн этгээд, хэвлэл,мэдээллийн байгууллага.
--	---

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
--	---

Албан тушаал:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

ЖАМБАЛЦЭРЭН
 (Гарын үсэг) 9132287
 УКА0078
 1116126541
 (Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)
 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

Байгууллагын нэр:
 ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
 Шийдвэрийн огноо: 20 02 21
 Дугаар: 60


Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:
 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
 Шийдвэрийн огноо: 2020.03.20
 Дугаар: 476

(тамга/тэмдэг)
 ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

(Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)
 20-ны өдөр



**ЖЕНДЭРИЙН ТАЛААР 2022 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн тайлан
1	ХХААХҮ-ийн салбарт жөндөрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх /эхний үе шат 2018-2021 он/	<p>Монголын эмэгтэйчүүдийн сан Европын Холбооны дэмжлэгтэйгээр Хил хязгааргүй малын эмч нар ба агрономичид (ХХМЭБА), Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчин, эв нэгдлийн бүлгэм (ЖЭРЭС) олон улсын байгууллагуудтай хамтран “ИМПАКТ – Хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд жөндөрийн эрх тэгш оролцоог хангах” төслийг 2020 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж байна. ИМПАКТ төсөл нь алслагдсан орон нутгийн иргэдийн эрх тэгш оролцоог дэмжсэн эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх загвар боловсруулах зорилготой. Төслийн хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийг чадавжуулж, шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нь нэмэгдүүлэх; эрчим хүчний хэмнэлтийн шийдлүүд, үйлдвэрлэлийн дэвшилтэт дадал, туршлагыг нэвтрүүлэх; хүрээлэн буй орчинд ээлтэйгээр байгалийн нөөцийг ашиглах замаар нэмүү өртөг шингэсэн орон нутгийн тогтвортой ноолуур, органик ногоо тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.</p> <p>Энэхүү төслийн зорилго, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах жөндөрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний үе шаттай (2018-2021) давхцаж байгаа бөгөөд тус бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиглэл, арга хэмжээг тодруулах үүднээс энэхүү үнэлгээний ажлыг гүйцэтгэв.</p>
2	Ажлын орчин нөхцөл, ажил-ар гэрийн тэнцвэрийн талаар санал хүсэлт гаргах, хамтран шийдвэрлэх нээлттэй, найрсаг, харилцан итгэлцсэн уур амьсгал, соёлыг бий болгох чиглэлээр олон улсын туршлагыг судлан нэвтрүүлэх	<p>Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан салбарын хүүхэд хамгааллын бодлогыг батлуулахаар байгууллагын эцэг эхийн зөвлөлийн хурлаар шийдвэрлэн, төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. ГБХЗГ-ын зөвлөх Б.Жавзанхүүтэй санал солилцож бодлогын төслийг эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд танилцуулав. Удахгүй эцэслэн батлагдахаар харьяа байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2-т “Хүүхэд бүр цэцэрлэг” хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн БЗД-н 1-р хорооны нутаг дэвсгэрт буюу өөрийн эзэмшил газар дээр ХХААХҮЯам болон харьяа байгууллагын ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг дэмжих зорилгоор 100 хүүхдийн ортой цэцэрлэгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, Улсын комисс хүлээн авч 2020 оны 10-р сараас үйл ажиллагааг эхлүүлсэн. Энэхүү цэцэрлэг нь БЗД-н 1-р хорооны 59-р цэцэрлэгийн салбар цэцэрлэг болж байгаа бөгөөд нийт 4 бүлэгтэй, 02-05 насны хүүхдүүдтэй, 1 бүлэгт 2 багш ажиллаж байна. Тус цэцэрлэгт яам болон харьяа байгууллага, 1-р хорооны хүүхдүүд хамрагдаж байна. Төрийн байгууллагууд дэргэдээ цэцэрлэг байгуулснаар ажиллагсдынхаа нийгмийн томоохон асуудлын нэгийг шийдвэрлэж, өглөө, оройд хүүхдээ авахад гардаг хүндрэл багасах, ажлын байрны бүтээмж өсөх зэрэг эерэг хандлагууд гарахаас гадна яамны нийт албан хаагчид энэ ажлыг бүрэн дэмжиж байгаа болно.</p> <p>Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхтэй холбогдуулан 2020 оноос хойш Нийслэл, дүүргийн холбогдох байгууллагуудад удаа дараа хүсэлт тавьсаны дагуу яамны цэцэрлэгийн ойр орчмын машин замыг засварлуулсан болно.</p> <p>Эцэг эхийн зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдын ажил ар гэрийн тэнцвэрийг хангах, дэмжих зорилгоор байгууллага дээр хүүхдийн өрөө байгуулахаар судалж байна.</p>

		Аймгийн ХХААГ-т 4 байгууллага хүүхдийн өрөө байгуулсан. 3 аймаг хүүхдийн өрөө байгуулахаар суллагч засвар хийж байна.
3	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хорооны 82 дугаар хуралдаанд тайлан хамгаалахад мэдээллээр хангах	<p>“Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” конвенцийг НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг устгах хороо (CEDAW)-нд Монгол Улс 10 дахь удаагийн тайланг хэлэлцүүлэх, хамгаалахтай холбогдуулан тус яамны Малын генетик нөөцийн хэлтсийн даргын хамт вакуумжиж доорх мэдээллийг ажлын хэсэгт хүргүүлж ажиллалаа.</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөөгийн эмэгтэйчүүдийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ - Ковид-19 халдварын үед салбарын тогтвортой хөгжлийг жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаагаар дэмжих, нийгэм, соёл, эдийн засгийн цогц арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх, - Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлсэн бодлогын томоохон шийдвэрүүд. <p>Тайланг 06 сарын 23-24-ны өдрүүдэд ГХЯаманд хамгааллаа.</p>
4	Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.	<ol style="list-style-type: none"> 1. Жендэрийн үндэсний хорооноос санаачлан зохион байгуулж буй жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, эрэгтэй, эмэгтэйчүүдэд тулгарч буй жендэрийн талаарх асуудлыг мэдээлэхтэй холбогдуулан хандлагаа өөрчилж, хамтдаа үлгэрлэж, хайраа хайрлаж “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” аянд яам, харьяа агентлаг, байгууллагууд, орон нутгийн ХХААГ-ын нийт албан хаагчдыг нэгдэж, аяны хүрээнд зохион байгуулагдах цахим болон бусад үйл ажиллагаанд санаачлагатай, идэвхтэй оролцохыг уриаллаа. Энэхүү аяны нэг хэсэг болох Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулагдсан “Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” үндэсний чуулганы хүрээнд эрэгтэйчүүдийн амьдралын оролцоо, эрүүл мэнд, боловсрол, тулгарч буй бэрхшээл, манлайллын талаар Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны эрэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Батхишигийг урьж мэдээлэл сонсож харилцан ярилцлаа. Мөн аяны хүрээнд зохион байгуулагдсан “эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой сэдэв” цахим хэлэлцүүлэгт яамны жендэрийн салбар зөвлөлийн гишүүд, яам, харьяа байгууллага, салбарын ТББ-ын 23 албан хаагчийг хамрууллаа. 2. 12-р сарын 1-ний өдрийн жендэрийн зөвлөлдөх семинарт харьяа 2 агентлагийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнг хамруулав. 3. 12-р сарын 8-ны өдөр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөөг танилцуулах хурлыг байгууллагын мэдээллийн цагаар ЖҮХ-той хамтран зохион байгууллаа. Яам болон харьяа байгууллагын 85 албан хаагч оролцов.
5	Хоршооны хөгжлийн үнэлгээнд эрэгтэй, эмэгтэй гишүүдийг оролцуулах	<p>Хоршооны хөгжлийн үнэлгээг 21 аймгийн 330 сум, нийслэлийн 9 дүүрэгт 2022 онд хийсэн байна. Үнэлгээнд хамрагдсан 2228 хоршооны 54,5 хувь нь гишүүдийн ба зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг, 54,1 хувь нь жендэрийн тэгш байдлыг хангаж ажилладаг гэсэн дүн гарчээ.</p> <p>Хоршооны бүхий л үйл ажиллагаанд эмэгтэй, эрэгтэй гишүүдийг жигд, идэвхтэй оролцуулах нь жендэрийн эрх, тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлдэг. Хоршооны жендэрийн тэгш байдлын үзүүлэлтээр 2228 хоршоог үнэлэхэд 15,9 хувь хангалтгүй, 26,1 хувь хязгаарлагдмал, 30,9 хувь нь дундаж, 20,3 хувь буюу 436 хоршоо хангалттай, 7,1 хувь буюу 152 хоршоо маш сайн гэсэн үнэлгээ авсан.</p> <p>Хоршооны эмэгтэй гишүүд бусад эрэгтэй гишүүдийн адил эрх эдэлж чадаж байгаа, эмэгтэй хүн тухайн хоршооны гишүүнээр элсэхэд ямар нэгэн саад бэрхшээл байдаггүй, хоршооны удирдлагад эмэгтэйчүүд сонгогдох боломжтой талаар хоршоод үнэлгээ өгчээ. Гэвч үнэлгээнд</p>

		<p>хамрагдсан хоршоодын 42,0 хувь нь жендэрийн тэгш байдлын талаар хангалтгүй үнэлгээ авсан байна. Энэ нь өрхийн тэргүүнээр гишүүнчлэгдсэн гол төлөв малчдын хоршоодод давамгайлж байгаатай холбоотой байна.</p> <p>Үнэлгээнд хамрагдсан 2228 хоршооны 54,5 хувь нь гишүүдийн ба зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг, 54,1 хувь нь жендэрийн тэгш байдлыг хангаж ажилладаг гэсэн дүн гарчээ.</p>
6	<p>“Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аян” арга хэмжээг зохион байгуулж яам болон харьяа байгууллага, аймгийн ХХААГ-ын цахим хуудсаар сурталчлан олон нийтэд түгээх.</p>	<p>1. Жендэрийн үндэсний хорооноос санаачлан Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор өрнүүлж буй “Харилцан хүндэтгэе” аянд нэгдэн “Монгол эрчүүдийн өнөөгийн байдал” сэдвээр 3-р сарын 18-ны өдөр ЖҮХ-ны ажлын албатай хамтран бүх албан хаагчдад мэдээлэл, танилцуулга хийв. Мөн энэ талаар яамны вэбсайт болон пейж хуудас, ЖҮХ-ны пейж хуудсанд тус тус байршуулав. /https://mofa.gov.mn/new, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны пейж хуудас/</p> <p>2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам түүний харьяа агентлаг ЖДҮГ “НАНДИН БҮХНЭЭ ХАМГААЛЪЯ-ӨӨРИЙГӨӨ, ГЭР БҮЛЭЭ, ОРЧИН ТОЙРНОО” уриан дор жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аянд нэгдэж байгаа талаар мэдээлэл бэлтгэж яамны болон ЖДҮГ-ын вэб хуудас, пейж хуудсанд тус тус байршуулан мэдээг ЖҮХ-нд хүргүүлэв. Мөн удирдлагын шуурхай хуралдаанд ХХААХҮ-ийн Дэд сайд М.Ганхүлэг мэдээлэл хийж аянд нэгдэхийг яамны нэгжийн дарга нар болон харьяа байгууллагын дарга нарт уриаллаа. /https://mofa.gov.mn/new, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны пейж хуудас/</p>
7	<p>Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлд бизнес эрхлэгчдийг хамруулах</p>	<p>Төсөл хүлээн авах хугацаанд нийт 867 төслийн 105.4 тэрбум төгрөгийн хүсэлтийг ирүүлснээс цахим системд 608 аж ахуйн нэгж 87.8 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтээ баталгаажуулсан байна.</p> <p>Төслийн хорооны хурлаар 5 үе шаттай үнэлж гэрээ байгуулж санхүүжилт олгох 156 зээлдэгчид 19,9 тэрбум төгрөгийн зээл олгосон.</p> <p>Нийт 156 зээлдэгчээс эрэгтэй захирал 80, эмэгтэй захирал 76 байна. Зээлийн нарийвчилсан мэдээ 2023 оны 1 сарын сүүлээр гарна.</p>
8	<p>ХАА-н салбарт хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламжинд бизнес эрхлэгчдийг адил нөхцөлөөр тэгш, хүртээмжтэй хамруулахад жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх</p>	<p>Төсөл хөтөлбөрийн хүрээнд хамтран хэрэгжүүлсэн ажлаас:</p> <p>1. Экспортыг дэмжих төсөл:</p> <p>2022 онд бүтээгдэхүүн экспортлох сонирхолтой аж ахуйн нэгж, иргэдийн экспортын чадамжийг сайжруулах, нэмэгдүүлэх төслийн ерөнхий зорилгын хүрээнд 20 удаагийн сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан бөгөөд үүнд 2333 хүн оролцсоноос 711 нь эмэгтэй, 1622 нь эрэгтэй байв.</p> <p>2. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл:</p> <p>- <u>Бичил, жижиг дунд бизнес эрхлэгчид буюу эмэгтэйчүүдийн бүлгийн үйл ажиллагааг дэмжих</u></p> <p>Төслийн 6 аймгийн 24 сумын хэмжээнд 1895 гишүүн бүхий 250 эмэгтэйчүүдийн бүлэг байгуулсан ба үүний 70% буюу 1335 нь эмэгтэй гишүүн байдаг. Хөдөөгийн бичил, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зорилтын хүрээнд эмэгтэйчүүд давамгайлсан бүлэг байгуулах, батлан даалт бүхий зээлд хамруулах, зах зээлтэй холбох зэрэг ажлуудыг хэрэгжүүлж, хөдөө аж ахуйн хоршоодыг дэмжих чиглэлд “Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо” ТББ-тай хамтран ажиллаж байна.</p> <p>Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн өгсөн зөвлөмжийн дагуу зээлийн бүлэгт бус иргэнд олгох, мөн төслийн эхний шат хэрэгжсэн Булган, Хөвсгөл, Говь-Алтай аймгуудад хэрэгжүүлэхээр ХААН банктай Хамтран ажиллах гэрээ байгуулсан. 2022 оны 11-р сарын 30-ны өдрийн</p>

байдлаар 806 зээлдэгчид 9,757.2 сая төгрөг зээл олгосноос 40 аж ахуйн нэгжид 2,442.2 сая төгрөг, 766 иргэнд 7,315.0 сая төгрөгийн зээл олгогдоод байна. Батлан даалтын хувьд 392 зээлдэгчид 2,749.2 сая төгрөгийн батлан даалт олгоод байна.

Нийт зээлдэгчдийн 71% эмэгтэй, 20% буюу 104 (төслийн зорилт 144) нь зорилтот 24 сумын эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүн байна.

Аймаг, сумын төвийн орлого багатай иргэдийн өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилтын хүрээнд эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүдийн 70-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх, 30-аас доошгүй хувь нь ядуу, өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байхаар бүлгүүдийг зохион байгуулсан.

- Сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт

Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд тус бүр 20 гаруй удаагийн технологийн болон талбайн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Төрийн хэмнэлтийн хууль батлагдсантай холбогдуулан сургалтуудыг ач холбогдлоор нь эрэмбэлж, боломжтой сургалтуудыг цахимаар зохион байгуулсан.

Хүснэгт. 2022 онд зохион байгуулагдсан сургалтууд

№	Сургалтын нэр	Зохион байгуулсан газар	Сургалтын байгууллага	Хамрагдсан хүний тоо	
				Нийт	Эм
1	Банкны зээлийн сургалт семинар	Улаанбаатар	ТХН, ЗБДН, ХААН банк, Төрийн банк	52	30
2	Шинэ хоршоодыг чадавхжуулах сургалт	Цахим	ТХН, мэрэгцсэн зөвлөх	60	42
3	Хоршоодыг чадавхжуулах, ХАА-н биржтэй холбох сургалт	Улаанбаатар	МХААХҮХ, ХАА-н бирж	30	12
4	Эрэлт тулгуурласан технологийн сургалт	Цахим	МХААХҮХ, мэргэжлийн зөвлөхүүд	265	159
5	Хоёр дахь удаагийн технологийн сургалт	Цахим	МХААХҮХ, мэргэжлийн зөвлөхүүд		
6	БАМБ-ийг чадавхжуулах сургалт	Архангай	Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо, ГХГЗЗГ, МЭЕГ	120	48
7		Дорнод		130	52
8	Малын эмч, лабораторийн шинжлэгч эмч нарын шимэгчтэх өвчний сургалт	Төслийн 6 аймагт	МЭЕГ	130	65
9	Малын дайвар бүтээгдэхүүнийг зөв дадлаар бэлтгэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх боломж	Дундговь	Монголын дайвар бүтээгдэхүүн эрхлэгчдийн тэргүүн	53	25

			холбоо ТББ		
10	Малын чанар сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэхэд малын үржлийн биотехнологийн дэвшилтэт аргыг ашиглах	Дундговь	Малын удмын сангийн үндэсний төв	65	20
11	Малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах	Дундговь	Бэлчээр хадлан судлалын нийгэмлэг	45	15
	НИЙТ			950	468

Шинэ хоршоодыг чадавхжуулах сургалтын хүрээнд, төслийн хүрээнд эмэгтэйчүүдийн бүлгээс үүссэн хоршоодыг чадавхжуулах, хоршооны бизнесийг тодорхойлж, зах зээлээ өргөжүүлэхэд нь зөвлөмж чиглэлээр хангах 2 өдрийн цахим сургалтыг 6 сарын 9-10 ны хооронд зохион байгуулж төслийн зорилтот 6 аймагт шинээр үүсэн 15 хоршоо болон эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүд, аймаг сумын ХХААГ-ын ажилтнууд зэрэг 60 орчим хүн хамрагдлаа.

3. Азийн хөгжлийн банк, ядуурлыг бууруулах япон сангийн санхүүжилттэй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл”

1. Орон нутгийн 245 барилгын ажилчид болон иргэнд ДОХ/БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан ба тэдний 74 буюу 30% нь эмэгтэй оролцогчид байна. Үүнд:

- Хан Империа ХХК - 52 ногоочдыг,
- Цомбон тоосго ХХК - Тэлмэн сумын 68 иргэн,
- Алтайн үндэс ХХК - орон нутгаас ажиллуулж буй 21 иргэн,
- Бридж констракшн ХХК - 28 иргэн
- Хаппи бьюлдинг ХХК - 35 иргэн
- Нью констракшн ХХК - 23 иргэн
- Жинсийн орой ХХК - 18 иргэнийг хамруулсан байна.

2. 10 услалтын системийн барилгын ажилд орон нутгаас нийт 176 ажилчин ажилласаны 32 буюу 18% нь эмэгтэйчүүд, 22 буюу 12.5% нь эмзэг бүлгийн өрхүүд байна. Эдгээрийг компани тус бүрээр харвал:

- Завхан аймгийн Хүрэн тал -31 ажилтан (6 эмэгтэй, өрх толгойлсон эмэгтэй 2)
- Говь-Алтай аймгийн Ёлтон – 13 эрэгтэй (6 эмэгтэй) ажилтан
- Говь-Алтай аймгийн Цахир – 25 (эмэгтэй 7, өрх толгойлсон эмэгтэй 2)
- Баян-Өлгий аймгийн Улаандэл - 31 эрэгтэй (эмэгтэй 1, ядуу, эмзэг өрхийн 3)
- Баян-Өлгий аймгийн Цул-Улаан - 14 эрэгтэй
- Завхан аймгийн Ногоон хашаа – 9 ажилтан (1 эмэгтэй)
- Сэлэнгэ аймгийн Ивэн гол – 15 ажилтан (3 эмэгтэй, эмзэг өрхийн 4)
- Төв аймгийн Сөгнөгөр - 7 иргэн (4 эмэгтэй, өрх толгойлсон 3 эмэгтэй)
- Хэнтий аймгийн Дулааны тал - 19 ажилтан (1 эмэгтэй)
- Ховд аймгийн Боомын ам – 12 ажилтан (3 эмэгтэй, 1 өрх толгойлсон эмэгтэй)-г барилгын ажилд авч ажиллуулсан байна.
- Барилгын гүйцэтгэгчид 2022 онд 120 (240-өөс) ажилтан авч ажиллуулахаас 176-г ажиллуулсан ч эмэгтэй болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийг ажиллуулсан байдал хангалтгүй (эмэгтэй 32, өрх толгойлсон эмэгтэй 8) байна.

		<p>- Орон нутгийн иргэдэд зориулсан БЗДХ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх сургалтыг 2022 онд 600 (1175) хүнд хүргэхээс 245 хүнд хүргэсэн ба тэдний 74 нь (30%) эмэгтэйчүүд байна.</p> <p>Энэхүү тайланд 2022 оны Нийгэм, Жендэрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар тусгав. ТУГА-д тусгагдсан ЖУАТ-ний нийт 20 үйл ажиллагаанаас 2022 оны 12-р сарын 20-ны байдлаар 1 нь биелэгдэж, 15 үйл ажиллагаа хэрэгжиж байгаа бөгөөд 4 ажлын эхлэх хугацаа болоогүй байна. Төслийн үндсэн 20 шалгуур үзүүлэлтийн 14 нь жендэрийн холбогдолтой байгаагийн 1-ийг нь биелүүлсэн бөгөөд, 13 нь хэрэгжих шатандаа явж байна. Төслийн дизайн, мониторингийн зорилтын хэрэгжилтийн хувьд нийт гүйцэтгэлийн үр дүнгийн 7 нь жендэрийн зорилтот түвшинтэй бөгөөд бүгд үргэлжилж байна.</p>
9	Бусад хэрэгжүүлсэн ажлын талаар	<ol style="list-style-type: none"> 1. ЗГХЭГ-с ирүүлсэн албан бичгийн дагуу Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал хүргүүлэв. 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги 2022-2031 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд холбогдох газруудаас санал авч ЖҮХ-д 2022 оны 01/866 тоотор хүргүүлэв. 3. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Засаглалын бодлогын 4.2.7-д заасны дагуу 2 арга хэмжээний биелэлтийг 2022 оны хагас жилийн байдлаар гаргаж ЖҮХ-д хүргүүлэв. 4. ЖҮХ-с ирүүлсэн зааврын дагуу ХХААХҮЯамны жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг боловсруулж ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/207 дугаар тушаалаар шинэчлэн батлуулав. 5. ЖДҮГ-аас хөгжлийн бэрхшээлтэй ЖДҮ эрхлэгчийн мэдээллийг авч ЖҮХ-д хүргүүлэв. 6. ЖҮХороо, Сангийн яамтай хамтран зохион байгуулсан Жендэрийн тэгш байдлыг хангах салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргазүйгээр хэрхэн дэмжих талаар хэлэлцэх зорилготой уулзалтад БТГ-ыг оролцуулав. 7. Глобал Пресс Жоурнал олон улсын цахим сэтгүүлийнхэнтэй уулзаж жендэрийн талаар, залуу малчдын талаар санал солилцов 8. Монголын эмэгтэйчүүдийн сантай хамтран ажиллаж жендэрийн талаар 2022 онд хэрэгжүүлэх ажилд хамтран ажиллахаар тус яамны холбогдох газрын мэргэжилтнүүдтэй уулзах уулзалтыг зохион байгуулав. 9. Жендэрийн үндэсний хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу Филиппин Улсад болох "Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийн удирдлага" бүсийн семинарт Хуулийн хэлтсийн даргыг оролцуулав. 10. Жендэрийн үндэсний хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу: - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний, салбарын бодлого, төлөвлөлт, тусгай арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих хамтын ажиллагааны хүрээг тогтоох зорилгоор болох уулзалтанд БТГ-ын дарга болон сайдын олон нийттэй харилцах ажилтныг; - Жендэрийн сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтанд МЭЕГ болон ЖДҮГ-ын холбогдох 2 мэргэжилтэнг; - Хэвлэл мэдээллийн ажилтанд зориулсан сертификат олгох сургалтанд хэвлэл мэдээллийн ажилтныг; - Филиппин Улсын Манилла хотод болох "Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийн удирдлага" бүсийн семинарт Хуулийн хэлтсийн даргыг тус тус хамруулахаар цахимаар мэдээлэл хүргүүлэв. 11. Жендэрийн үндэсний хороо болон Азийн Хөгжлийн Банк хамтран Япон Улсын Засгийн газрын санхүүжилтээр "Иргэний нийгмийн оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь" техникийн туслалцааны төслийн хаалтын үйл ажиллагаанд газрын даргын хамт оролцов. 12. "Ноолуурын салбарын жендэрийн дүн шинжилгээ"-ний үр дүнг танилцуулах цахим хэлэлцүүлэгт 2 газрын дарга болон хөнгөн үйлдвэрийн салбар хариуцсан мэргэжилтэнг оролцуулав.

		13.12-р сарын 7-ны өдөр Жендэрийн салбар зөвлөлийн хурлаар АХБ-аас “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл 2” (ХААХХТ2) төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан жендэрийн үйл ажиллагаа болон нийгмийн хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон Жендэрийн салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг танилцуулж хэлэлцүүлэв.
--	--	---

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ